

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар

2026 оны I улирал

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Үр нөлөө	Цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ	Үнэлгээ
ЗГ-ын албан даалгавар							
1	1	Сар шинийн баярын өдрүүдэд онцгой байдлын өндөржүүлсэн бэлэн байдлыг хангах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах "Хариуцлагатай шуурхай алба" ажиллуулах тухай 2026-02-11 Дугаар 2026_01	1.5.1.. 1.5. Шадар сайд Т.Доржханд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд М.Бадамсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 1.5.1.хүнсний худалдаа, үйлчилгээний газруудад эрүүл ахуйн болон хадгалалт, хамгаалалтын горимыг мөрдүүлэх, хяналтыг чангатгах;	Сар шинийн баярыг угтан аймгийн хэмжээнд ХХААГ, ЭМГ, МЭГ-ын холбогдох хяналтын чиглэлийн улсын байцаагчид хамтран урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 17, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 1, гурилан бүтээгдэхүүний 11, зах худалдааны төвийн 2, хүнсний худалдааны 21, ургамлын гаралтай бүтээгдэхүүн худалдааны 10, мах, сүү, сүүн бүтээгдэхүүний худалдааны 2, үзэсгэлэн худалдааны 1, ил задгай худалдааны 1, ресторан 2, кафе 3, цайны газар 5 нийт 76 объектын 51 аж ахуйн нэгж, 23 иргэн хамруулан зохион байгууллаа. Хяналт шалгалтын явцад 160 зөрчил илрүүлж, 110 зөрчил буюу 69%-ийг газар дээр нь арилгуулсан. Хүнсний сүлжээний үе шатанд хэрэгжүүлэх зохистой дадал, дотоод хяналтын хэрэгжилт, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар, аюулгүй байдлын баталгаажилт, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр илэрсэн зөрчилтэй холбогдуулан 8 объектод 50 заалт бүхий хугацаатай албан шаардлага хүргүүлж гүйцэтгэлийн хяналтыг хийж ажилласнаар биелэлт 85%-тай байна.	Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийн 69%-ийг газар дээр нь арилгуулж, илэрсэн зөрчилтэй холбогдуулан 8 объектод 50 заалт бүхий хугацаатай албан шаардлага хүргүүлж гүйцэтгэлийн хяналтыг хийж т 85%-ийг нь биелүүлэн иргэдийг шаардлага хангахгүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хэрэглээнээс урьдчилан сэргийлж,	Урьдчилан сэргийлэх болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийх	100%

			<p>Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч хадгалах хугацаа дууссан 6 нэр төрлийн 609 ширхэг нийт 2.9 сая төгрөгийн үнэ бүхий пиво худалдан борлуулж байгаа зөрчлийг илрүүлж, акт үйлдэн, хураан авч, захиргааны журмаар эд зүйл хураах, устгах, улсын орлого болгох орон тооны бус зөвлөлд шилжүүлэн ажилласан. Тухайн аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуульд заасны дагуу торгуулийн арга хэмжээ ногдуулан зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж ажилласан.</p> <p>Мөн шалгалтын явцад 1 аж ахуй нэгжээс 2 нэр төрлийн 17 дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулж, хүнсний аюулгүй байдлыг хангаж бараа бүтээгдэхүүн худалдан авах, хэрэглэгчийн хяналтыг сайжруулах талаар 51 аж ахуйн нэгж, 82 иргэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт шалгалтын мэдээллийг цахим хуудсанд 2 удаа нийтэлсэн.</p>	хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангасан.		
2	1.5.2.. үнийн зохиомол хөөрөгдөл үүсгэхгүй байх талаар хяналт тавьж ажиллах.	<p>Сар шинийн баярыг угтан аймгийн хэмжээнд ХХААГ, ЭМГ, МЭГ-ын холбогдох хяналтын чиглэлийн улсын байцаагчид хамтран урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ, зах худалдааны төв, үзэсгэлэн худалдаанд нийт 76 объектын 51 аж ахуйн нэгж, 23 иргэнийг хамруулан зохион байгуулж хүнсний аюулгүй байдлыг хангах, үнийн зохиомол хөөрөгдөл үүсгэхээс урьдчилан сэргийлж ажилласан.</p> <p>Аймгийн хэмжээнд хүн амын хаврын улирлын нөөцийн мах бэлтгэн нийлүүлэх аж ахуйн нэгжийн сонгон шалгаруулалт хийгдэж Эрдмийт ХХК 110 тонн үхрийн мах, 80 тонн хонины мах, Энгэр Мөрөн ХХК 10 тонн</p>	Махны үнийн зохион хөөрөгдөл бий болоогүй байна.	Нийтийг хамарсан баяр, наадмын үеэр үний зохиомол хөөрөгдөл үүсэхээс урьдчилан сэрглэх хяналт шалгалтыг тухай бүрд зохион байгуулах.	50%	

			ямааны мах нийлүүлэхээр шалгарч гэрээ байгуулсны дагуу 2026 оны 03 сарын 15 өдрөөс эхлэн Баян-Өндөр суманд 29, Жаргалант суманд 3, нийт 32 дэлгүүрээр үхрийн мах 14500 төгрөг, хонины мах 12500, ямааны мах 8000 төгрөгөөр худалдаалж махны үнийн зохиомол хөөрөгдөл үүсгэхээс сэргийлэн ажиллаж байна. 2026 оны 03 сарын 31-ний өдрийн байдлаар нийт 12.1 тонн мах борлуулагдсан байна.			
3	3.Эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд "Хариуцлагатай шуурхай алба"-ыг байгуулж, нэгдсэн удирдлага, мэдээллийн урсгалыг зохион байгуулж, тогтмол хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай	Сар шинийн баярын өдрүүдэд аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, аж ахуйн нэгж байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих зорилгоор аймгийн Засаг даргын 2026 оны А/149 дүгээр захирамжаар Хариуцлагатай эргүүл, жижүүрийн хуваарийг гарган хэрэгжилтийг хангуулж ажилласан. Тус ажлын хүрээнд сар шинийн баярыг угтан Сар шинэ-2026 тусгай арга хэмжээг зохион байгуулах салбар төлөвлөгөөг боловсруулан 2-р сарын турш иргэдийн эрүүл аюулгүй амьдрах эрхийг хангах тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил явуулж, иргэдэд залилах, хулгайлах зэрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, гарын авлага, сэрэмжлүүлэг түгээж ажиллалаа. Энэ хүрээнд иргэдэд хуурамч архи худалдан авах, хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэх 1000 гаруй хуудас түгээж, томоохон зах, худалдааны төвүүдэд 500 гаруй зөвлөмж байршуулан, сэрэмжлүүлэх рийл бичлэг хийн "Орхон хууль эрх зүйн хэлтэс" пэйжээр түгээсэн. Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын гэр хорооллын 17 багийн айл өрхөд Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүн үзлэг хийн заавар, зөвлөгөөг	Ноцтой осол аваар, гэмт хэрэг зөрчил, ус, дулаан, цахилгаан хангамжийн доголдол гараагүй	Цаашид баяр ёслол, бүх нийтийн амралтын өдрүүдэд болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариуцлагатай эргүүл, жижүүрийг томилгоожуулан ажиллуулах	100%	

			<p>өгч багийн Засаг дарга нарт удирдамжийг танилцуулан ажилласан. Удирдамжийн хүрээнд нийт 6553 айл өрхийг хамруулж гал түймэр гарч болзошгүй 1125 зөрчлийг илрүүлж шалгалтын явцад 226 зөрчлийг арилгуулан ажилласан.</p> <p>Хариуцлагатай эргүүл, жижүүрийг 2026 оны 02 дугаар сарын 17-23 ны өдрүүдэд ажиллуулж аймгийн ерөнхий эргүүлд нийт 153 албан хаагч томилогдон ажилласан. Мөн аймгийн хэмжээнд ажиллаж буй төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд дотооддоо хариуцлагатай жижүүрийн хуваарийг гарган томилон ажиллуулсан. Дээрх хугацаанд Цагдаагийн газрын 102 дугаарын утсанд 234, эрүүл мэндийн 346 дуудлага ирсний дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан бол Булган аймгийн нутаг дэвсгэрт цасанд суусан тухай 1 дуудлага ирсний дагуу Онцгой байдлын газрын алба хаагчид ажиллаж тусламж үйлчилгээг үзүүлсэн. Сар шинийн баярын өдрүүдэд ус, дулаан, цахилгаан хангамжийн доголдол гараагүй болно.</p>			
	4	<p>4.. 4.Албан даалгаврын хэрэгжилтийг 2026 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 08:00 цагаас 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 09:00 цаг хүртэлх хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж, аюул, осол, онцгой нөхцөл байдлын мэдээллийг Засгийн газрын Шуурхай албанд 2 цаг тутамд хүргүүлж байхыг Засгийн газрын</p>	<p>Цагаан сарын баярын өдрүүдэд аймгийн хэмжээнд аюул, осол, онцгой нөхцөл байдал бий болооогүй ба тухайн хугацаанд аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт ажилласан тухай тайланг 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдөр Онцгой байдлын Ерөнхий газарт хүргүүлсэн.</p>	Аймгийн хэмжээнд аюул, осол, онцгой нөхцөл байдал бий болоогүй	Цаашид баяр ёслол, бүх нийтийн амралтын өдрүүдэд болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариуцлагатай эргүүл, жижүүрийг томилгоожуулан ажиллуулж, тайлан мэдээллийг	100%

			гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.			холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллах.	
2	5	Төрийн зарим үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх талаар авах зарим арга хэмжээний тухай	1.1.1.. 1.1.Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 1.1.1.иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэж байгаа үйлчилгээг оновчилж, хүсэлт шийдвэрлэлтийн явцыг тухай бүр иргэн, хуулийн этгээдэд эргэн мэдэгдэх нөхцөлийг бүрдүүлэх;	Аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас өргөдөл гомдол, санал хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэлтийн явцыг тухай бүр иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад эргэн мэдэгдэх нөхцөлийг бүрдүүлж "Эрдэнэт-Иргэн" https://irgen.erdenet.mn/ системийг 2022 оноос Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн хөгжүүлж ашиглалтад оруулан үйл ажиллагаандаа ашиглаж хэвшсэн. Тус системийг Засгийн газрын 1111 төв, улсын хэмжээнд ашиглаж буй өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийн нэгдсэн санд холбох ажлыг 2026 оны эхний хагас жилд багтаан хийхээр системийн хөгжүүлэлтийг хийх ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. "Эрдэнэт-Иргэн" /irgen.erdenet.mn/ системээр дамжуулан 2025-2026 онд нийт 709 иргэнээс гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэн хариуг хүргүүлсэн байна.	Иргэд орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр өргөдөл, гомдол, санал хүсэлтээ гаргах боломжтой болсон төдийгүй өргөдлийн шийдвэрлэлтийн явцыг хүссэн үедээ харах боломжтой болсон нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад цаг хугацаа, эдийн засгийн хэмнэлтийг гаргаж чадсан байна.	"Эрдэнэт-Иргэн" /Irgen.erdenet.mn/ системийг Засгийн газрын 1111 төв, улсын хэмжээнд ашиглаж буй өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийн нэгдсэн санд холбох	100%
	6	2026-02-11 Дугаар 2026_02	1.1.2.. 1.1.1.эрхлэх асуудлын хүрээнд ашиглаж байгаа мэдээллийн системийг мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем /system.gov.mn/- д бүртгэх;	Аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудад ашиглаж буй "Эрдэнэт И-Оффис" төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн багц системийг мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем болох system.gov.mn -д бүртгэж тус системийн асуулгад бүрэн хамрагдаж бүртгүүлсэн. Босоо удирдлагатай нутгийн захиргааны байгууллагуудад ашиглагдаж буй мэдээллийн системүүдийг дээд шатны төрийн захиргааны төв	Мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем болох system.gov.mn -д бүртгэгдсэнээр улсын хэмжээнд	-	100%

			байгууллагууд хариуцан ажилладаг тул нутгийн захиргааны байгууллагуудаас бүртгүүлэх боломжгүй.	нэгдсэн сан бий болж байна.		
7		1.1.3. төрийн байгууллага ашиглаж байгаа мэдээллийн системд гадаадын иргэнийг таньж, баталгаажуулан цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;	Аймгийн хэмжээнд ашиглаж байгаа "Эрдэнэт И-Оффис" систем нь төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагаанд зориулан хөгжүүлсэн систем тул гадаадын иргэнийг таньж, баталгаажуулан цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлага үүсэхгүй. ГХБХБГ, УБХ, ХХҮГ, Цагдаагийн газар, Татварын газар зэрэг босоо удирдлагатай нутгийн захиргааны байгууллагуудаас иргэн, аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээг гадаадын иргэнийг таньж, баталгаажуулан цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхдээ Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia.mn/-ийг ашиглан үйлчилгээг үзүүлж байна.	Төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн.	-	100%
8		1.1.4. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэн, хуулийн этгээдэд хүргэхдээ Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia.mn/-ийг ашиглах, ижил зорилготой мэдээллийн систем, гар утасны аппликейшнийг тус системд нэгтгэх.	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэн, хуулийн этгээдэд хүргэхдээ Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia.mn/-ийг ашиглан аймгийн хэмжээнд 3 байршилд байрлах "Хурдан төв"-үүдээр дамжуулан операторын үйлчилгээгээр нийт 43 байгууллагын 550 үйлчилгээг иргэдэд хүргэж байна. 2026 оны эхний улиралд "Хурдан төв"-үүдээр дамжуулан төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор) И-Монгол, И-Бизнес платформ, төлбөрийн системийг ашиглан 5723 иргэнд үйлчилгээ үзүүлэн, мэдээллээр ханган ажиллалаа. Мөн "Хурдан" киоск төхөөрөмжүүдээр иргэд, аж ахуйн нэгжүүд, төр хувийн хэвшлийн 60 гаруй байгууллагын 661 үйлчилгээг 24/7 цагаар авах боломжийг бүрдүүлэн аймгийн хэмжээнд нийт 12 байршилд байршуулан тогтмол хяналт тавин ажиллаж байгаа ба тайлант оны	Төрийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, иргэдэд ойртсон.	Цаашид төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia.mn/-ээр үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх	100%

			эхний улиралд "Хурдан" киоск төхөөрөмжөөр 15637 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. Мал эмнэлгийн нэгдсэн цахим системд мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээ, төлөвлөгөөт арга хэмжээний хэрэгжилт, эрт илрүүлэг, оролцоот эпидемиологи зэрэг үйл ажиллагааны бүртгэл мэдээллийг нэгтгэн оруулж холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна Мал эмнэлгийн нэгдсэн цахим системийг e-mongolia.mn системтэй холбох хүсэлтийг Мал эмнэлгийн ерөнхий газарт гаргасан боловч шийдвэрлэгдээгүй байна.				
3	9	Онцгой нөхцөл байдлын асуудлаар авах арга хэмжээний тухай 2026-03-04 Дугаар 2026_03	2.1.. 2.Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлд дараах арга хэмжээг авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов: 2.1.Албан даалгаврын хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, нарийвчилсан төлөвлөгөө гарган арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллах, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах;	Байгаль цаг агаарын болзошгүй аюултай болон гамшигт үзэгдлээс анхааруулах, сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх мэдээг нөхцөл бүрдсэн үед 2026 оны 1 улиралд цаг агаарын анхааруулах, сэрэмжлүүлэх мэдээг 17 удаа иргэд, олон нийтэд хүргэсэн. Мөн Цаг агаарын, шар усны үерээс урьдчилан сэргийлэх мэдээг малчид, тээвэрчид, зам, барилгын компани, албан хаагчдын гар утсанд масс мессэжээр аймгийн Онцгой комиссоос давхардсан тоогоор нийт 3458 хүнд, E-mail хаягаар 969 хүнд, https://eoffice.erdenet.mn/ Эрдэнэт И-Оффис системээр 43503 хүнд, http://alarm.weather.gov.mn/ цаг агаарын урьдчилсан сэрэмжлүүлэх системд "Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв" facebook хаягт тус тус мэдээлсэн. Хаврын улирал эхэлсэнтэй холбогдуулан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай сумдын Засаг даргын захирамжийг гарган ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, байгаль орчны багц хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтмол эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулж, 3	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлж ажилласнаар аливаа гамшиг эрсдэлд өртөөгүй. - Мал, амьтны гоц халдварт өвчин, мал, амьтнаар дамжин халдварлах, өвчин гараагүй. Малын зүй бус хорогдол буурч, төл хүлээн авах бэлтгэл бүрэн хангагдсан. Хаврын тариалалт зхийхэд улаан	Мал аж ахуйн хаваржилт, төл бойжилтийн мэдээ, судалгааг авах болон төрийн үйлчилгээг малчдад хүргэх зорилгоор сумдад ажиллах. Хаврын тариалалтыг технологийн дагуу зохион байгуулах	50%

			<p>дугаар сарын 20-оос эхлэн хуурайшилтын мэдээ буюу ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх мэдээг 34 удаа зохиож байгаль орчны байцаагч, Сум дундын ойн ангийн албан хаагчид болон иргэдэд түгээсэн.</p> <p>Аймгийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн мал тооллогоор 169.6 мянган толгой мал тоологдсоноос 1257 толгой мал, амьтан малын зүй бусаар хорогдсон байна. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2026 оны А/29 дүгээр тушаалын дагуу мал, амьтны гоц халдварт өвчин, мал, амьтнаар дамжин халдварлах, өвчин гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн талбай, өвөлжөө, хаваржааны ойр орчмын малын сэг зэмийг цуглуулж устгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар нийт 556 сэг зэмийг утсган 1350 мкв талбайд 32 кг Ни-сор ариутгалын бодисоор цацах аргаар Баян-Өндөр суманд “Бөхөнгийн өврийн төвлөрсөн цэг, Жаргалант суманд Ухаа толгой устгалын цэгт устгал, халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Малыг хорогдол багатай даван туулах, төл хүлээн авах бэлтгэл ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2026 оны А/69, А/108 дугаар захирамж болон аймгийн Онцгой комиссийн шийдвэрийн дагуу улсын болон аймаг, сумын нөөцөөс нийт 7 эх үүсвэрээс 3 удаагийн тараалтаар давхардсан тоогоор 4963 малчин, мал бүхий иргэдэд 250 тонн өвс, 182.5 тонн тэжээл, 1.5 тонн долоодос олгож малчдад дэмжлэг үзүүлэх төдийгүй тэдэнд хүн, мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлэн малчдын санал, хүсэлтийг сонсохоор, Баян-Өндөр, Жаргалант сумдын 10 чиглэлд Хүнс, хөдөө аж ахуйн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн</p>	<p>буудайн үрийн нөөцөөр 100 хувь хангагдсан.</p>	
--	--	--	--	---	--

			<p>газар, Мал эмнэлгийн газрын нийт 40 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаж нийт 406 малчин өрхөөр орж, 291 хүнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, зөвлөгөөг өгч ажилласан.</p> <p>Аймгийн хэмжээнд 75.3 мянган толгой эх мал төллөхөөс 3470 толгой эх мал буюу 4.6 хувь нь төллөж байна.</p> <p>2026 онд тариалах талбай, хураан авах ургацын төлөвлөгөөг боловсруулан баталж, аймгийн хэмжээнд 5420.7 га талбайд тариалалт хийхээр бэлтгэл ханган ажиллаж байна.</p> <p>Хаврын тариалалтын бэлтгэл ажлын хүрээнд орон нутагт хадгалж буй үрийн нөөцийн судалгааг аж ахуйн нэгж, иргэн тус бүрээр гаргахад аймгийн хэмжээнд 5 сортын 690 тн үрийн улаанбуудай, 2 сортын 366 тн үрийн төмс хадгалагдаж байгаа нь хаврын тариалалтад шаардлагатай үрийн улаанбуудайг 100 хувь, үрийн төмсний 70 хувийг хангахаар байна.</p> <p>Хаврын тариалалтын түлшний хангамж, үнийн өсөлтийг зохицуулах үүднээс ХХААХҮЯ-аас хэрэгжүүлж буй ажлын хүрээнд үнийн нэмэгдэлгүй түлш авах тариаланчдын захиалгыг авч нэгтгэн, 11 аж ахуйн нэгж 20 иргэн нийт 134 тонн түлш авах хүсэлтийг Монголын Тариаланчдын Үндэсний Холбоонд хүргүүлсэн.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Оюутан-цэрэгт”-т цэргийн мэргэжил олгох сургалтын журам, батлан хамгаалах сайдын 2026 оны А/51 дагуу тушаал, Орхон аймгийн Засаг даргын А/261 дүгээр захирамжийн дагуу</p>		
--	--	--	---	--	--

				<p>сургалтад хамрагдах хүсэлтэй оюутан, суралцагчийг 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 10 хоногийн хугацаанд бүртгэж нийт аймгийн хэмжээнд 93 оюутан, суралцагчид бүртгэлд хамрагдаж эрүүл мэндийн үзлэг, биеийн тамирын шалгалтад орсон.</p> <p>Шалгаруулалтаар тэнцсэн оюутан, суралцагчид “Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын “цэргийн ерөнхий бэлтгэл” шатны сургалтад 2026 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс 06 дугаар сарын 14-нийг хүртэл 7 хоногийн Бямба, Ням гаригуудад 2 багц буюу 96 цагийн онолын сургалтыг зохион явуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна.</p>			
	10		<p>2.2.. 2.2. Ажлын хариуцлага алдсан, холбогдох үндэслэл тооцоо, судалгааг муу хийж, алдаатай шийдвэр гаргасан албан тушаалтанд тухай бүр нь хариуцлага тооцож, олон нийтэд мэдээлж ажиллах;</p>	<p>Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх явцад ажлын хариуцлага алдсан, холбогдох үндэслэл тооцоо, судалгааг муу хийж, алдаатай шийдвэр гаргасан албан тушаалтан байхгүй болно.</p>	<p>Ажлын хариуцлага алдсан, холбогдох үндэслэл тооцоо, судалгааг муу хийж, алдаатай шийдвэр гаргасан албан хаагч байхгүй</p>	<p>Албан хаагчдын ажлын хариуцлагыг хүрсэн түвшингээс бууруулахгүй байх, улам сайжруулах талаар хяналт тавьж ажиллах</p>	100%
4	11	<p>Онцгой нөхцөл байдлын асуудлаар авах арга хэмжээний тухай 2026-03-04 Дугаар 2026_03</p>	<p>2.3.. 2.3. Өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлээгүй болон ёс зүйн зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах.</p>	<p>Тус ажлыг хэрэгжүүлэх явцад өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлээгүй болон ёс зүйн зөрчил гаргасан албан тушаалтан байхгүй болно.</p>	<p>Өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлээгүй болон ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй</p>	<p>Цаашид ёс зүйн болон ажлын технологийн зөрчилгүй хамт олон байхад анхаарч ажиллана</p>	100%